

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН**



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-17
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	18-38

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	18
2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	18-38

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 04 дүгээр
сарын 12-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен;

Чөлөөтэй: Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Б.Идэрчулуун, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, мөн газрын ахлах шинжээч С.Сарангэрэл, Судалгаа мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх албаны дарга Д.Дуламсүрэн, Удирдлагын академийн Хууль, эрх зүйн тэнхимийн эрхлэгч А.Алтанзул, Монгол Улсын Их сургуулийн багш, дэд профессор Д.Оюунгэрэл нар оролцов.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 3, 4, 6, 7, 10, 11, 12, 13, 15, 16, 17, 18, 19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Баттөмөр: 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 4
Бүгд: 7
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 4
Бүгд: 7
42.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Эрүүгийн хууль,” “Авлигын эсрэг хууль,” “Захиргааны ерөнхий хууль,” “Хөдөлмөрийн хууль,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 4

Бүгд: 7

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4.4 дэх хэсэг нэмэх:

“4.4.Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“төрийн албан хаагийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг;

5.1.2.“төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.3.“төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Удирдлагын академийн Хууль, эрх зүйн тэнхимийн эрхлэгч А.Алтанзул хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийг “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим

6.1.Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

- 6.1.1.хүнлэг, энэрэнгүй байх;
- 6.1.2.үнэнч, шударга байх;
- 6.1.3.хариуцлагатай байх;
- 6.1.4.манлайлах;
- 6.1.5.хамтач байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.8-7.1.11 дэх заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.8.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;

7.1.9.байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

7.1.10.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;

7.1.11.багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.

7.2.Төрийн албаны тухай хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.4, 4.1.7, 4.1.9-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно.

7.3.Төрийн албаны тухай хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

“8 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага

8.1. Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1. иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;

8.1.2. эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;

8.1.3. бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;

8.1.4. бусдын ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

8.1.5. бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх;

8.1.6. албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

8.1.7. албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

8.2. Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно:

8.2.1. төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;

8.2.2. удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;

8.2.3. хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах;

8.2.4. албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;

8.2.5. үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох, үйлдэл хийх;

8.2.6. соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;

8.2.7. албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

8.2.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Удирдлагын академийн Хууль, эрх зүйн тэнхимийн эрхлэгч А.Алтанзул хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их хурлын гишүүн Н.Энхболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**9 дүгээр зүйл.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
соён гэгээрүүлэх үйл ажиллагаа**

9.1.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1-д заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;

9.1.3.урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;

9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;

9.1.5.иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

12.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйл болгох:

**“10 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал
эрхлэх эрх бүхий этгээд**

10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

10.2.Засгийн газар нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.3.Ёс зүйн хороо /цаашид “Хороо” гэх/, Ёс зүйн дэд хороо /цаашид “Дэд хороо” гэх / нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана.

10.4.Хороо, Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хороо хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно.

10.5.Хороо, Дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13. Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл.Хороо, түүний бүрэн эрх

11.1.Хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна.

11.2.Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

11.3.Хороо нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан орон тооны бус 4 гишүүнийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж, чөлөөлнө.

11.5.Хорооны үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо батална.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

11.6.Хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

11.6.1.хуульд өөрөөр заагаагүй бол Дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

11.6.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

11.6.3.төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах;

11.6.4.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

11.6.5.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

11.6.6.томилох эрх бүхий этгээдээс ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих;

11.6.7.Дэд хорооны ажиллах журмыг батлах;

11.6.8.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, мөрдүүлэх;

11.6.9.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

11.6.10.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаар нэгдсэн тайлан гаргах;

11.6.11.хууль тогтоомжид заасан бусад.

11.7.Энэ хуулийн 7.2, 7.3-т заасан ёс зүйн хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомж, дүрмийн төсөлд Хорооны саналыг авна.

11.8.Хорооны гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгөө болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

14.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12 дугаар зүйл.Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

12.1.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

12.1.3.Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Хороо, Дэд хороонд гаргаж өгөх;

12.1.5.Дэд хорооны дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол хариуцлага хүлээлгэх;

12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Хороонд тайлагнах;

12.1.7.Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

12.1.8.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Дэд хорооны бүрэн эрх

13.1.Дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно.

13.2.Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно.

13.3.Дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

13.3.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

13.3.2.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;

13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;

13.3.5.ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Хороонд хүргүүлэх;

13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

13.3.7.хуульд заасан бусад.

13.4.Дэд хорооны гишүүн дараах баталгаагаар хангуулна:

13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;

13.4.2.хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;

13.4.3.шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

**“14 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар
гомдол, мэдээлэл гаргах**

14.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг энэ хуулийн 14.3-т заасан харьяаллын дагуу Хороо, эсхүл Дэд хороонд гаргана.

14.2.Гомдол, мэдээлэлд албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

14.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:

14.3.1.Дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

14.3.2.Засгийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, харьяалах дээд шатны Дэд хороогүй байгууллагын удирдах албан тушаалтан болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн;

14.3.3.Хороо нь төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтан болон энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т зааснаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, Авлигын эсрэг хуулийн 4.1.4-т заасан этгээдийн.

14.4.Хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хянан үзэж, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15 дугаар зүйл болгох:

“15 дугаар зүйл.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх

15.1.Энэ хуулийн 14.3-т заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

15.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга мэдээлэл авах;

15.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;

15.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;

15.1.4.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;

15.1.5.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах.

15.2.Дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа, эсхүл биечлэн гардуулснаар дараах этгээдэд мэдэгдсэнд тооцно:

15.2.1.гомдол, мэдээлэл гаргасан этгээд;

15.2.2.зөрчилд холбогдсон төрийн албан хаагч;

15.2.3.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага.

15.3.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

15.4.Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

15.5.Иргэний гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

15.6.Дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд, түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороо, Хороонд гомдол гаргаж болно.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.7.1.дүгнэлтийг хэвээр үлдээх;

15.7.2.дүгнэлтийг хүчингүй болгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16 дугаар зүйл болгох:

“16 дугаар зүйл.Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх

16.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Хороо, Дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:

16.1.1.гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;

16.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;

16.1.3.байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;

16.1.4.төрийн албанаас халах.

16.2.Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

16.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасныг зөрчсөн бол тухайн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

16.4.Төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.5.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

16.6.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох:

“17 дугаар зүйл.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураар хүлээх

17.1.Хороо, Дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

17.2.Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:

17.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;

17.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19 дүгээр зүйл болгох:

“19 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.

19.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.

19.3.Хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хүргүүлнэ.

19.4.Хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд шинээр бүлэг, хэсэг, зүйл, заалт нэмэгдэж, хасагдсантай холбогдуулан төслийн бүтэц, дугаарлалт, найруулгын холбогдох өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Б.Баттөмөр: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “37.1.12” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 4

Бүгд: 7

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Б.Баттөмөр: Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн санлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Б.Баттөмөр: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Б.Баттөмөр: Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх:

“2/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлгээс гадна зарлагын мэдүүлгийг мэдүүлж байх талаар санал боловсруулж, холбогдох хуульд тусгах

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;" гэсэн санлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим
10 цаг 43 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА
ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН
12-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баттөмөр: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд хурлын ирц, ирсэн гишүүдийг танилцуулъя.

УИХ-ын гишүүн Энхболд ирсэн байна. УИХ-ын гишүүн Бат-Эрдэнэ ирсэн байна. УИХ-ын гишүүн Адъяаа ирсэн байна. УИХ-ын гишүүн Баделхан ирсэн байна. УИХ-ын гишүүн Баярсайхан ирсэн байна. Бусад гишүүдийн хувьд бол ингээд ирж байгаа байх гэж ингэж бодож байна. Хэн Энхбаяр гишүүн яасан, Энхбаяр гишүүн алга байна. Бейсен гишүүн орон нутагт байгаа юм байна. Энх-Амгалан гишүүн алга байна. Энх-Амгалан гишүүн хуралдаа оръё. Бусад гишүүд байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглаврыг батлах тухай”

Байнгын хорооны тогтоолын төсөл байна.

2 дахь нь, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг УИХ-ын гишүүн Бат-Эрдэнэ, Баярсайхан нарын гишүүдээс 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн энэ хуулийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төсөл.

Цаглаврыг та бүхэнд тараасан байгаа.

Тэгээд уншиж танилцуулах юм уу, яах юм. Энэ цаглавар дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Цаглаврыг ингээд баталчихъя.

Дараагийн асуудалдаа оръё. Санал хураах бил үү.

Тийм, ингээд цаглаврыг санал хураалт явуулъя.

Байнгын хорооны тогтоолыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Тогтоолын төсөл 57.1%-ийн саналаар батлагдлаа.

10.47 цаг

Дараагийн 2 дахь асуудал.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоомжийн төслүүдийг УИХ-ын гишүүн Бат-Эрдэнэ, Баярсайхан нараас 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийе.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуулийн төсөлтэй холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэг Баатарзориг ТАЗ-ийн дарга, Идэрчулуун ТАЗ-ийн гишүүн, Амартөгс ТАЗ-ийн гишүүн, Бат-Эрдэнэ ТАЗ-ийн Маргаан хянан шалгах газрын дарга, Сувдмаа ЗГХЭГ-ын Хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг гүйцэтгэгч, Дуламсүрэн АТГ-ын хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын албаны дарга, Лхамжав байна уу? Ламжав байгаа юм байна. ТАЗ-ийн Сургалт судалгааны мэдээллийн хэлтсийн нэгдсэн сангийн ахлах референт, Сарангэрэл байна уу? Сарангэрэл байна. ТАЗ-ийн Маргаан таслах зөвлөлийн шинжээч, Алтанзул Удирдлагын академийн эрх зүйн танхимын эрхлэгч, Дарьхүү МУИС-ийн зөвлөх профессор ирээгүй байна. Оюунгэрэл, тийм байна. МУИС-ийн багш. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагчийн зүгээс Баттөмөр би танилцуулъя.

Монгол УИХ-ын гишүүн Баатарбилэг, Бат-Эрдэнэ, Баярсайхан нараас өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Их Хурлын чуулгын нэгдсэн хуралдааныг хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлсэн.

УИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 193 тоот захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хорооны нэгдсэн

хуралдаанд бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, УИХ-ын гишүүн Баттөмөр миний бие ахална. Бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн Мөнхцэцэг, Сандаг-Очир, Туваан, Нямаагийн Энхболд, нар ажиллалаа.

Ажлын хэсэг 4 удаа, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг 15 удаа хуралдаж, төслийг хэлэлцэх асуудлыг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэхэд УИХ-ын гишүүдээс төсөлтэй холбогдуулан гаргасан санал. Орон нутагт Хэнтий, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Ховд зэрэг болон Төрийн ордонд зохион байгуулсан хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэг дээр төрийн албан хаагчдаас гаргасан санал, түүнчлэн эрдэмтэн, судлаач, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгааг судлан үзлээ. Түүнчлэн уг хэлэлцүүлэгт уулзалтаар бол 101 иргэн, төрийн албан хаагчдаас 261 санал, ди парламент, цахим хаягаар 16 санал нийт 277 орчим санал ирүүлсэн бөгөөд хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн 50-аас дээш хувийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдыг хамруулах, хамтарч хариуцлагатай байх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол хэрхэн гаргах, төрийн өндөр албан тушаалтны нэр хүнд, ёс зүйн алдаа нь төрийн албаны нэр хүнд муугаар нөлөөлж байгаа талаар саналууд ирсэн. Ажлын дэд хэсэг ЗГХЭГ-ын холбогдох албан тушаалтныг, ТАЗ, АТГ, Удирдлагын академи, МУИС-аас эрдэмтэн, багш нарыг төлөөллийг оролцуулан байгуулж ажиллалаа.

Ингээд ажлын хэсэгт дараах байдлаар саналын томъёоллыг бэлтгэлээ. Үүнд:

1 дүгээрт нь, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль нь анхдагч хууль бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хүлээх хариуцлагыг олон

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

2 дугаарт нь, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн үйлчлэлд хамрах хүрээнд өргөтгөж төрийн албаны тухай хуульд заасан төрийн бүх албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн дарга, гишүүд, ерөнхий захирал, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа ТББ-ын удирдах албан тушаалтан, бүх шатны ИТХ-ын дарга, төлөөлөгч, Ирээдүйн өв сангийн корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүд хамрагдахаар нэмж тусгалаа.

3 дугаарт нь, төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуульд заасан зарчмаас гадна энэ хуулиар тогтоосон хүнлэг энэрэнгүй байх, үнэнч шударга байх, хариуцлагатай байх, манлайлах, хамтач байх зарчмыг баримтлахаар тусгалаа.

Төрийн албан хаагчийн дээрх зарчмын хүрээнд ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдөж түүнийг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтаас гадна энэ хуулиар тогтоосон үйл ажиллагааг хориглохоор тусгаж байна.

5 дугаарт нь, төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь хуулийн төслийн чухал хэсэг

мөн бөгөөд энэ талаар зохицуулалтыг шинээр нэмж байна.

6 дугаарт нь, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх ёс зүйн хороо, дэд хороо нь түүний бүрэн эрхийг хуульчилж, бие даасан хараат бус зарчмаар ажиллахаар тусгасан Ёс зүйн хороо болон орон нутгийн 5 Ёс зүйн хороо орон тооны 5, орон тооны бус 4, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй, Ёс зүйн дэд хороо нь тухайн байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллахаар тусгалаа

7.Ёс зүйн хороо нь төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтны, ЗГ-ын хэрэг эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны, дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчдын болон харьяалах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэхээр тусгалаа.

8 дугаарт нь, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Ёс зүйн хороо болон Ёс зүйн дэд хорооны холбогдох үнэлэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал анх болон давтан үйлдсэнийг нь харгалзан гомдол гаргагчид эс үгүй бол олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох, өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, албан байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах, төрийн албанаас халах хүртэл арга хэмжээг авахаар тусгасан байна.

9 дүгээрт нь, ёс зүйн бусад асуудлаар бусад орны туршлагыг харахад хууль болон дүрэм журмаар зохицуулдаг бөгөөд гол зохицуулалт нь төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, хориглох заалтаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлахыг шаарддаг бөгөөд төрийн албан хаагч нь хөрөнгө орлогын мэдүүлгээ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

мэдүүлэхээс гадна зарлагын асуудлыг авчирдаг учраас энэ талын зохицуулалтыг судалж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ЗГ-т чиглэл болгож байгаа.

Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ, ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа. Хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ийм танилцуулга байна.

Ингээд юу яая, санал хураалтад орох уу тийм ээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Баделхан гишүүгээр тасалъя. Баделхан.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ хуулийн төслөөр бол Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороо гэж бие даасан хараат бус зарчмаар ажиллана гэж хуулийн төсөлд туссан юм байна лээ тийм ээ. Тэгэхээр энэ бие даасан тийм орон тооны тийм байгууллага байгуулагдах юм уу, ер нь цаашидаа ямар журмаар яаж ажиллах вэ? Орон тоо нэмэгдэх үү? 1 ёсондоо гэсэн асуулт байна.

Б.Баттөмөр: Баделхан гишүүний асуултад хариулъя. Сс зүйн хороо нь болбол ТАЗ дээр бол байна. Энэ болбол нөгөө орон тоог хэмнэх, ажлын ачааллыг бас тодорхой хэмжээнд бий болгох энэ чиглэлээр ТАЗ-ийн 5 гишүүн байгаа. Энэ болбол ёс зүйн хорооныхоо 5 байна. Дээрээс нь 4 гишүүнийг болбол томилно, орон тооны бус 4 гишүүн байх. Энэ бол янз бүрийн төлөөллүүд байхаар ингэж бид нар тусгасан байгаа юм. 4 орон тооны асуудал, урамшууллын асуудал гарч ирнэ.

Дэд хороо бол тухайн тухайн байгууллагуудаар явчих учраас ямар нэгэн тийм орон тоо болбол гарахгүй гэж

ингэж тусгасан байгаа юм. ЗГ дээр болбол дэд хороо ЗГ бол дэд хорооны үүргийг гүйцэтгэнэ. Өөрийнхөө харьяаллын байгууллагын ажилтнуудынхаа ёс зүйн асуудлыг удирдах ажилтны ёс зүйн асуудлыг авч үзэхгүй, юу, Дэд хорооны үүргийг гүйцэтгэнэ. 25-аас доош тийм, ер нь бол жижиг албан байгууллагууд дээр болбол юу гэхээр 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тийм дэд ажлын хэсгүүд дэд ажлын тийм ээ, Ёс зүйн дэд хороо байх. Тийм Ёс зүйн дэд хороо байх, тэр нь асуудлаа шийдээд явах, тэр Ёс зүйн дэд хорооны юу чинь дарга нь яахаар сая өөрчилчихсөн үү? Тийм дотроосоо сонгож, дотроосоо сонгож ажиллахаар ингэж яасан байгаа. Алтанзул юм хариулах гээд байна уу үгүй юү? ингээд гол хариулт авчихлаа.

Асуулт асууж, хариулт авлаа.

Ингээд юу билээ? үүнээс. Одоо ингээд зарчмын зөрөөтэй саналууд дээр санал хураалт явна.

1 дүгээр зүйлтэй холбоотой, 1 дүгээр зүйлтэй холбоотой асуудлаар саналтай гишүүн байна уу, алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуудлаар асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалгана.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж ийм өөрчлөлт найруулсан байна. Ажлын

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэсгийн саналыг дэмжье ээ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Нямаагийн Энхболдын санал орсонгүй. Энхболд гишүүн. Нямаагийн Энхболдын гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Энэ миний санал хураах төхөөрөмж сая дэмжиж өгсөн чинь гарсангүй ажиллахгүй байх шиг байна. Дахиад хүчингүй болгоод, дахиж санал хураалгахыг хүсэж байна.

Б.Баттөмөр: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Бас болохгүй байна уу? Тэгэхээр болохгүй шүү дээ. Баярсайхан гишүүн. Баярсайхан гишүүнд микрофон өгье. Энэ аппарат ямар, техникийн улсуудад хэлээч. Энэ аппаратууд ажиллахгүй байна. Баярсайхан гишүүн

Б.Баярсайхан: Миний төхөөрөмж ажиллаагүй учраас саяын санал хураалтад би дэмжсэн санал өгсөн боловч ингээд уначихлаа, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Б.Баттөмөр: Энэ техникийн улсуудад хэлж энэ аппаратыг яахгүй бол аппарат минийх бас алдаг оног ажиллаад байна шүү. Энэ аппарат дээр анхаармаар байна.

Ингээд саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1%-ийн хувиар дэмжигдэж байна.

3 дугаарт нь, төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн дараах томъёоллоор санал хураалгана.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Эрүүгийн хууль,” “Авлигын эсрэг хууль,” “Захиргааны ерөнхий хууль,” “Хөдөлмөрийн хууль,” гэж тус тус нэмэх. Санал хураалт.

57.1% хувиар санал дэмжигдэж байна.

4. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж. 3 дугаар зүйлээр санал хурааж дууслаа.

Одоо төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах гэсэн санал байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Хэний, өө уучлаарай, минийх, Баделхан гишүүн. Баделхан гишүүн санал гаргая.

Х.Баделхан: Дахин санал хурааж өгнө үү. Энэ юу төхөөрөмж ажилласангүй.

Б.Баттөмөр: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал 57.1%-аар дэмжигдэж байна.

4 дүгээр төслийг доор дурдсан агуулгатай. Уучлаарай, одоо түрүүчийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уучлаарай.

57.1%-ийн саналаар дэмжигдэж байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төсөлд доор дурдсан агуулгатай 4.4 дэх хэсэг нэмэх:

“4.4.Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.” гэж, энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

4 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

5. төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“төрийн албан хаагийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг;

5.1.2.“төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.3.“төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг.” гэсэн ийм байна. Ингээд Энхболд гишүүн асуулт асууя.

Н.Энхболд: 5-ын 1-ийн 1 дээрээ ёс суртахуун гээд 5-ын 1-ийн 2 дээрээ ёс зүйн

гээд орчихсон, энэ чинь бид нар 1 жигдэлье гээгүй билүү? Эс үгүй бол энд зориуд тийм ёс суртахуун гэдэг үгээр орж байна уу?

Б.Баттөмөр: Алтанзул багш хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Алтанзул. Нэр томъёоны хувьд бол бас ялгаа байгаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гэдэг дээр хувь хүний, хувь этгээдийн асуудал явж байгаа учраас ёс суртахууны гэдэг нийтлэг шаардлага тавьсан. Ёс зүйн зөрчлийн хувьд бол энэ хуульд өөрөөр хэлбэл төрийн албан хаагчийн үүрэг, хориглох зүйлийг тусгайлан нийтлэг шаардлага болгож тавьж байгаа учраас ёс зүйн нийтлэг шаардлага гэсэн томъёог хэрэглэсэн.

Б.Баттөмөр: Зөвхөн энэ заалт дээр.

А.Алтанзул: Энэ заалт дээр, зөвхөн энэ заалт дээр байгаа, санаатай.

Б.Баттөмөр: Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-ийн саналаар санал дэмжигдлээ. 5 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалга.

6. Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийг “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА” гэж өөрчлөх. Энэ дээр ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна. Төслийн 6 дугаар зүйлийн санал хураалт явуулж дууслаа.

Ажлын хэсгийн бэлтгэсэн томъёоллоор санал хураалт хураалгана.

Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим

6.1.Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

6.1.1.хүнлэг, энэрэнгүй байх;

6.1.2.үнэнч, шударга байх;

6.1.3.хариуцлагатай байх;

6.1.4.манлайлах;

6.1.5.хамтач байх.” гэсэн ийм 5 зарчмыг бол нэмж тодорхойлсон байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-аар санал дэмжигч байна. 6 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу. Юу болчхов, алга тоничихоор тэгж байгаа байх. Цуцалъя. Тэр сая санал хураалтыг.

Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

7 дугаар зүйл дээр дахиад 1 санал байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.8-7.1.11 дэх заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.8.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;

7.1.9.байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

7.1.10.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;

7.1.11.багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.

7.2.Төрийн албаны тухай хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.4, 4.1.7, 4.1.9-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно.

7.3.Төрийн албаны тухай хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.” гэж ийм заалтууд байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн саналаар томъёоллоор санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Санал 71.4%-аар дэмжигдэж байна. 7 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Баярсайхан гишүүнд микрофон өгье.

Б.Баярсайхан: Энэ хуулийг өргөн барьсан боловч ажлын хэсэгт орж ажиллаагүй, саналаа ажлын хэсэгт бас зарчмын зөрөөтэй саналаар томьёолж гаргаж өгөөрэй гэсэн учраас 1 санал байгаа юм. Энэ 8 дугаар зүйл дээр би арай илүү тийм нарийвчилсан зохицуулалт оруулбал яасан юм бэ гэж та бүхэнтэйгээ зөвлөмөөр байна. Тухайлбал ёс зүйн зөрчлийг шинж байдал, нөлөөгөөр нь тодорхой ангилах зохицуулалт хийж өгөх шаардлагатай юм шиг санагдаад байгаа юм. Энэ нь ёс зүйн хөнгөн зөрчил юм уу эсвэл ноцтой зөрчил юм уу гэдэг дээр. Тэгэхээр ингэж ангилж үзэх юм бол хэд хэдэн 8-ын дугаар зүйлд 8-ын 2 дахь хэсэгт оруулаад 8-ын 2 дугаар заалтын 1-ийн 1-ийн 5, 1-ийн 2-ын 1, 1-ийн 2-ын 3, 1-ийн 2-ын 4, 1-ийн 8-ын 1-ийн 3, 3-ын 2, 8-ын 1-ийн 6-гийн 2 гээд энэ заалтууд дээр үүнийгээ тодотгож оруулах ийм боломж байна уу? Өөрөөр хэлбэл хөнгөн ноцтой гэж ангилснаараа эргүүлээд төрийн албан хаагчаа тушаал дэвших эсвэл эргээж дахин төрийн албанд орохгүй байх гэдгээ ялгаж өгвөл яасан юм бэ? Одоогийн бидний яваад байгаа энэ дүрэм маань болохоор зүгээр л ёс зүйн зөрчил байна. Тэгээд сануулна, хална гэж ингэж 1 яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь амьдрал дээр ерөөсөө хэрэгжихгүй.

Нөгөө талаараа энэ дээр бас хүмүүс хэлмэгдэх боломжтой. Төрийн албан хаагчид маань өөрсдөө гүтгүүлэх, доромжлогдох тийм юу бас амьдралд гарч байдаг учраас төрийн албан хаагчийнхаа 1 талаар нэр хүндийг нь хөнгөн ёс зүйн зөрчил байх юм бол 1 талаар нь хамгаалдаг байх ёстой юм болов уу тэгээд үүнтэй холбоотой би хэрвээ энэ зарчмын зөрөөтэй санал дэмжигдэх юм болбол 15 дугаар зүйл дээр

бас 1-ийн 4, 1-ийн 5 гээд энэ дээр энэ бас нэмж зарчмын зөрөөтэй санал гаргахаас өөр аргагүй болж байгаа юм. Одоо би энэ ТАЗ-ийнхөндөө байнга хэлээд байгаа нь 1 яаманд ёс зүйн зөрчил гаргасан, ноцтой зөрчил гаргасан мөртөө дараагийн яамандаа түүнээс илүү өндөр албан тушаал ингээд хашаад яваад байгаа байхгүй юу. Энэ чинь л нөгөө жинхэнэ яг чадлаараа ажиллаж байгаа төрийн албан хаагчдын зоригийг мохоох, хүслийг мохоох. Тэгээд ийм хүмүүс нь ингээд л дээшээ ахиад яваад байдаг 1 ийм л зүйлийг л бид нар зохицуулах шаардлагатай байгааг байгаа юм л даа.

Тэгэхээр би хөнгөн болон ноцтой зөрчил гэж ангилна гэдэг энэ зарчмын зөрөөтэй саналыг л 8-ын 2 дээр оруулах ийм саналтай байна. Тэгээд үүнийгээ хэрвээ ингэх юм бол доошоо хэд хэдэн зүйл заалтууд дээр бас зохицуулалт хийх шаардлагатай болж байгаа юм. Надаа 3 зарчмын зөрөөтэй санал байна.

Б.Баттөмөр: Ажлын хэсгийн гишүүн Нямаагийн Энхболд микрофон өгье.

Н.Энхболд: Энэ 16-гийн 1 дээр 1 ийм заалт байгаа. Баяраа гишүүн ээ. 16-гийн 1 дээр хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8-ын 1, 8-ын 2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хороо, дэд хорооны дүгнэлтийг үндэслээд зөрчлийн шинж байдал өөрийн чинь хэлж байгаа тийм ээ, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзаж үзээд тэгээд ялгавартай шийтгэл ноогдуулна гээд доор нь уучлал гуйхыг үүрэг болгох, өөрт нь сануулах, ганцаарчилсан хэлбэрээр сануулах, хамт олны өмнө сануулах, төрийн албанаас халах гээд энэ нөгөө хүнд хөнгөнөөр нь бас заавал харгалзаж үзнэ шүү гэсэн заалтууд нь энд орчихсон байгаа юм. Тэгэхээр урьд нь 8 дээр тэгж давтах хэрэг байна уу, үгүй юү гэдэг л асуудал байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүн тэр 16-г үз дээ. Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа. Тэгвэл 16 дугаар зүйл дээрээ арай жоохон нарийвчлаад, томъёолоод, тодруулаад оруулж ирвэл яах вэ, Энхболд дарга аа. 8 дугаар зүйлээ хэвээр нь үлдээвэл.

Б.Баттөмөр: Юу, 8-аа 16 дээрээ ярьчих уу, тэгвэл.

Б.Баярсайхан: Тэгээд үүнийгээ хангалттай гэж бүгдээрээ үзэх үү, тийм ээ. Ер нь ингэх шаардлага байна уу? Бүгдээрээ Ёс зүйн байнгын хороон дээрээ л үүнийгээ ярьчихвал цааш цаашидаа ...

Б.Баттөмөр: Манай ажлын хэсгээс хариулах хүн байна уу? Хэн хариулах вэ? Алтанзул хариулах уу? 3 номерын микрофоныг өгье.

Удирдлагын академийн багш Алтанзул Баярсайхан гишүүний саналын, асуудлын хүрээнд тайлбарлахад ноцтой зөрчлийн асуудал болбол ер нь тэр 8-ын 1-д заасан төрийн албаны хуулийн 37, 39-ийн асуудал бол сахилгын зөрчилтэй байгаа. Өөрөөр бол Төрийн албаны тухай хуульд байгаа бид нар 16 дээрээ уяж өгөөд, сахилгын хариуцлага тэнд хүлээнэ ээ гээд. Авлигын буюу нийтийн албан дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль товчилчихлоо. Тэр хуульд байгаа зүйл заалт нь болбол захиргааны зөрчил буюу торгох зэрэг зөрчил байгаа. Тэр нь болохоор бас энэ 16-гийн 1-ийн 3, 16 дугаар зүйлдээ уясан байгаа.

Харин 8-ын 1-д, манай энэ хууль маань өөрөө бол анхдагч суурь хууль учраас энэ хуулиудын ноцтой зөрчлүүдийг нь дурдаад энэ хуулийн суурь, ёс зүйн буюу ёс зүйн хэм хэмжээг сахихтай холбоотой ийм зохицуулалт нь энд орсон учраас энэ 8-ын 1, 8-ын 2-т байгаа зохицуулалт нь болбол анхан удаа үйлдэж байгаа болбол бид нар ёс зүйн хариуцлага буюу хөнгөн хэлбэрийн хариуцлагууд хүлээгээд энэ зөрчлийг болбол давтан үйлдэж байгаа

тохиолдолд нөгөө зөрчлийнхөө шинж байдал буюу давтамжаас нь шалтгаалаад тэр бусад сахилгын болон захиргааны зөрчлийн зохицуулалтууд ороод ингээд явж байгаа.

Харин таны санал дээр түрүүн ярьсан нөгөө 1 байгууллагад ёс зүйн зөрчил үйлдээд дахиад өөр шатлан дэвшиж байгаа процессыг нарийвчлан судлах асуудал дээр саналыг нь оруулж өгсөн байгаа.

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Тэгэхээр бүгдээрээ юун дээр анхан үйлдсэн гэдгээр нь бид нар шинж байдлыг бас тогтоох нь учир дутагдалтай шүү дээ тийм ээ? Анх удаа үйлдэж байгаа мөртөө саяын тэр төрд ажиллаж байгаа хүний гэрийнх нь икафаас тэр их хэмжээний мөнгө гарч ирж байгаа анхны удаа гарч ирж байгаа юм шиг ийм нөхцөл, бэлгийн хүчирхийлэл, албан тушаалаа урвуулан ашигласан байдал гээд ийм нийгэмд энэ хүмүүсийг төрд итгэх итгэлийг алдагдуулах ийм ноцтой зөрчлийг анх удаа үйлдэхдээ гаргасан бол энэ чинь бас хөнгөрөх юу нөхцөл болж явж болохгүй л байгаад байна л даа.

Б.Баттөмөр: Энхболд гишүүнд микрофон өгье. Ажлын хэсгийн гишүүн.

Н.Энхболд: Жишээ нь тэд тэр хүмүүс эрүүгийн, зөрчлийн, сахилгын, хариуцлага хүлээлгэх энэ юмнууд чинь дараагийн тэр 16-гийн 4 дээр нь дахиад байж байгаа. Жишээ нь бэлгийн дарамт чинь эрүүгийн хэрэгт орно шүү дээ. Тэгэхээр хэрэв тийм асуудалд орчихсон бол мэдээж яах вэ, ёс зүйн хариуцлага хүлээлгэе гээд орчихгүй л байх гэж найдаж хуулиа хийж байгаа шүү дээ. Эрүүгийн анх байна уу, 2 дахь байна уу, саяын таны хэлсэн шиг тийм гэмт хэргүүд үйлдчихсэн бол тэрийг ёс зүйн асуудал гэж үзэхгүй эрүүгийн хэрэг гэж үзээд л шууд тэр 16-гийн 4-ийнхөө дагуу

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

шийтгэлээ зохих хуулийнхаа дагуу хүлээгээд л явчихна гэсэн үг.

Б.Баттөмөр: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Бас хөндөж байгаа асуудал болбол зүйтэй. Тийм 16 дээр болбол тэр үед ярья, чиний хойшоо явах юунд.

Ингээд Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага

Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;

8.1.2.эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;

8.1.3.бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;

8.1.4.бусдын ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

8.1.5.бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх;

8.1.6.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

8.1.7.албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

8.2.Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно:

8.2.1.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;

8.2.2.удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;

8.2.3.хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах;

8.2.4.албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;

8.2.5.үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох, үйлдэл хийх;

8.2.6.соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;

8.2.7.албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

8.2.8. албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.” гэсэн ийм саналууд байна.

Энхболд гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Би энэ саналуудыг дэмжиж байгаа. Зүгээр өчигдөр бас энэ Ёс зүйн хариуцлагын тухай хуулийн тухай мэдээлэл явахад гишүүний хэлсэн үгийг буруу ойлгосон юм уу, эс үгүй бол мушигаад байгаа юм уу, бараг энэ хууль дээр шорттой явах тэгнэ, ингэнэ, өвдөгний хэмжээ гэж юм биччихсэн юм шиг юм сүлжээн дээр гарчихсан байна лээ. Тийм огт байхгүй гэдгийг хэлчихье, албан ёсоор. Энэ хууль дээр. Зүгээр энэ эрх бүхий байгууллагаас баталсан хувцасны шаардлагыг баримтал аа л гэж байгаа юм. Энэ бол тэр сүлжээн дээр яваад байх шиг ийм ойлголт байхгүй. Жишээ нь цэргийн байгууллага гэж бодоход цэргийнхээ хувцсыг албан үүргээр биелүүлэхдээ өмсөж байх ёстой, өөр одоо албан үүргээ биелүүлж байхдаа ийм дүрэмт хувцастай байна уу гэдэг юм уу, эс үгүй бол ийм шаардлага тавина, тавигдана тэрийг дагаж биелүүлнэ гэсэн л ерөнхий утгатай. Байгууллага болгон дээр ч ийм юм байхгүй, ийм шаардлага тавьдаг байгууллага ч бий, тавьдаггүй байгууллага ч байгаа. Жишээ нь эмнэлгийн сувилгач болбол эмнэлгийнхээ л хувцастай явна уу гэхээс биш ямар энгийн хувцастай яваад байлтай биш. Тийм ээ, тийм санааг агуулсан заалт шүү гэдгийг бас хэлье. Тэгэхгүй бол бас буруу ойлгоод, хуулийн маань талаар, хуулийн маань талаар 1 тийм юм явчихсан байна лээ гэдгийг зүгээр тодруулаад хэлчихье гэж бодсон. Дэмжиж байгаа саналуудыг бол.

Б.Баттөмөр: Энхболд гишүүн маш чухал санааг хэллээ. Тийм буруу мэдээлэл явж байна лээ. Энд бол тэр хувцаслалт гэдэг бол тухайлбал гаалийн байцаагч бол гаалийн формоо хэрэглэнэ, шүүхийн шийдвэр биелүүлэх газрын ажилтан шүүхийн шийдвэрийнхээ, прокурор бол прокурорынхоо хувцсыг

хэрэглэнэ шүү дээ. Энэ утгаар л энэ хуульд орж байгаа. Түүнээс биш өөр янз бүрийн юм бол байхгүй гэдгийг бас нэмээд хэлчихье ээ.

Ажлын хэсгийн саналыг дэмжье ээ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна. 8 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

9. төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалгана.

Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар бүлэг нэмэх:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ.
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

9 дүгээр зүйл. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

9.1. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1-д заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1. төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

9.1.2. төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;

9.1.3. урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;

9.1.5.иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.” гэсэн ийм 5 асуудал байна.

Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна. 9 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Уучлаарай 9 дээр дахиад санал байгаа юм байна. Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн томъёоллоор санал хураалгая.

12.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйл болгох:

“10 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд

10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

10.2.Засгийн газар нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлыг Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.3.Ёс зүйн хороо /цаашид “Хороо” гэх/, Ёс зүйн дэд хороо /цаашид

“Дэд хороо” гэх / нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана.

10.4.Хороо, Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хороо нь хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно.

10.5.Хороо, Дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.”гэсэн ийм заалтууд байна.

Баярсайхан гишүүн санал байгаа юм байна. Баярсайхан гишүүнд микрофон өгье.

Б.Баярсайхан: Би энэ дээр яг яаж томъёолох тийм ээ, юу зүгээр бодоод яваад байгаа болохоос биш яг хэлж мэдэхгүй л байгаад байна л даа. Ер нь бол байгууллага дотроос хамгийн ёс зүйтэй хүмүүсээ нэрсээр нь шалгаруулаад л ингээд ёс зүйн хороогоо байгуулаад л явдаг, соён гэгээрүүлэх ажил бол төдийлөн бас хийгдэхгүй байгаад байдаг. Энэ хороо бол маш сайн ажиллах шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ ерөөсөө ийм зүгээр чив чимээгүй 1 хүний асуудал орж ирэхээр хэлэлцчихээд л огт соён гэгээрүүлэх ажил хийдэггүй, үндсэн ажлаа хийхгүй байвал энэ дээр яах юм бол.

Нөгөөтээгүүр энэ дээр ямар нэгэн байдлаар 1 хүнийг хэлмэгдүүлэх юм уу эсвэл Ёс зүйн хороондоо ёс зүйгүй хүн сонгогдоод хэн нэгнийг хэлмэгдүүлэх тохиолдол байдаг. Амьдрал дээр байдаг, тэгээд энэ дээр бол би яг зохицуулалтыг нь бол хэлж мэдэхгүй байна. Манай ТАЗ-ийнхөн ийм кэйсүүдтэй бол нэлээн л тулгарч байсан байгаа. Тэгээд би энэ дээр л та нарынхаа бас 1 санаа оноог сонсчихмоор байх юм.

Б.Баттөмөр: 1 номерыг нь микрофоныг Бат-Эрдэнэ хариулна. ТАЗ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ТАЗ-ийн Маргаан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ байна. Гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөлд маань хуулийн төслийн 11-ийн 6-гийн 7 дахь заалт байгаа. Энэ дээр бол хороо нь дэд хорооны ажиллах журмыг батлахаар ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ дэд хорооны ажиллах нарийвчилсан журам бол хуулийг дагаад гарна. Мөн хуулийн 13 дугаар зүйл дээр байгаа, дэд хорооны бүрэн эрх гээд, энэ дээр гишүүний асуусан зохицуулалтуудыг маш тодорхой зохицуулсан байгаа. Энэ өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргана. Мөн энэ дүгнэлтээ хүргүүлдэг. Харьяа байгууллага буюу өөрийнхөө энэ бүтцийн байгууллага дотор ёс зүйн асуудлаар зөвлөгөө өгдөг, дүгнэлт гаргадаг, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулдаг. Энэ зөрчлийнхөө тайлан мэдээг хороонд бол яг тогтоосон хугацаанд мэдээлж байх ийм зохицуулалтыг бол нарийвчлаад заагаад өгчихсөн байж байгаа.

Мөн гишүүний асуултад гарсан хүнийг хэлмэгдүүлэх ийм асуудал гарах уу гэж байгаа. Энэ дээр бид нар энэ хянан шийдвэрлэх процессын асуудлыг 5 дугаар бүлэг дээрээ оруулж өгсөн байж байгаа. Гомдол мэдээллийг гаргаад ёс зүйн дэд хороо дүгнэлтдээ үнэхээр тэр албан тушаалтны буруутай үйл ажиллагаа ёс зүйн зөрчил гаргасан байна гэдэг ийм дүгнэлт гаргана. Энэ дүгнэлт дийг үндэслээд байгууллагын удирдах албан тушаалтан нь ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох энэ шийдвэрээ гаргана. Харин энэ байгууллагын албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргаагүй гээд энэ хороо маань, дэд хороо маань дүгнэлт гаргачихвал энэ дүгнэлтийг нь харьяалах дээд шатны дэд хороонд ахиж гомдол гаргах давхар хянуулах энэ боломж бололцоог нь олгочихсон байж байгаа.

Үнэхээр албан хаагч нь өөрөө, би энэ ёс зүйн зөрчлөө гаргачихсан гэдгээ хүлээн зөвшөөрөх юм болбол энэ сахилгын шийтгэлээ юу ёс зүйн зөрчилд

хариуцлагаа хүлээгээд ингээд энэ гомдол, мэдээлэл маань зогсоод, гомдол гаргасан иргэнээсээ уучлалтаа гуйх юм уу, сануулах энэ шийтгэлээ аваад ингээд зогсоно. Үнэхээр тэр гомдол гаргагч маань төрийн албан хаагчийг хамгаалсан шийдвэр гаргачихлаа гэж үзэх юм бол харьяалах дээд шатны хороонд бол энэ давхар шалгуулах энэ гомдлоо гаргаж болно оо.

Ингээд дээд шатны дэд хорооны шийдвэрийг үнэхээр ахиад иргэн маань үндэслэлгүй гэж үзэх юм бол шүүхийн байгууллагад хандах энэ эрх нь бол бас нээлттэй байж байгаа.

Б.Баттөмөр: Асуулт асууж, хариулт авлаа. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна.

11. Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалгая.

13. Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл. Хороо, түүний бүрэн эрх

Хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна.

Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

11.3.Хороо нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Энэ хуулийн 11.3-т заасан орон тооны бус 4 гишүүнийг Улсын Их Хурлын

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос томилж, чөлөөлнө.

11.5.Хорооны үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо батална.

11.6.Хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

11.6.1.хуульд өөрөөр заагаагүй бол Дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

11.6.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

11.6.3.төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах;

11.6.4.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

11.6.5.энэ хуулийн 15.1-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

11.6.6.томилох эрх бүхий этгээдээс ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих;

11.6.7.Дэд хорооны ажиллах журмыг батлах;

11.6.8.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим сүлжээг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, мөрдүүлэх;

11.6.9.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

11.6.10.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаар нэгдсэн тайлан гаргах;

11.6.11.хууль тогтоомжийн заасан бусад гэсэн байна.

11.7.Энэ хуулийн 7.2, 7.3-т заасан ёс зүйн хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомж, дүрмийн төсөлд Хорооны саналыг авна.

11.8.Хорооны гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр хүндийг хүндэтгэх, өөртэй нь болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй.” ийм саналууд байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 11 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

12. Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12.Томилох эрх бүхий албан тушаалтны эрх

12.1.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл байдал, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

12.1.3.Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамжуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Хороо, Дэд хороонд гаргаж өгөх;

12.1.5.Дэд хорооны дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол хариуцлага хүлээлгэх;

12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Хороонд тайлагнах;

12.1.7.Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

12.1.8.хуульд заасан бусад.” гэсэн ийм саналууд байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёолоор санал хураалт явуулъя.

57.1%-аар санал дэмжигдэж байна. Төслийн 11-ээр санал хураалт дууслаа.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрөөтэй саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Дэд хорооны бүрэн эрх

13.1.Дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно.

Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно.

Дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

13.1.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

13.3.2.энэ хуулийн 15.1-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;

13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

13.3.5.ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Хороонд хүргүүлэх;

13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

13.3.7.хуульд заасан бусад.

13.4.Дэд хорооны гишүүн дараах баталгаагаар хангуулна:

13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;

13.4.2.хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;

13.4.3.шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах гэсэн ийм саналууд бол байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.1%-аар санал дэмжигдэж байна. 12 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрөөтэй саналтай гишүүд байна уу? Алга байна. Бэлтгэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

“14 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг энэ хуулийн

14.3-т заасан харьяаллын дагуу Хороо болон Дэд хороонд гаргана.

Гомдол, мэдээлэлд албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

14.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:

14.3.1.Дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;

14.3.2.Засгийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, харьяалах дээд шатны Дэд хороогүй байгууллагын удирдах албан тушаалтны болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн;

14.3.3.Хороо нь төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан болон энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т заасан болон төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, Авлигын эсрэг хуулийн 4.1.4-т заасан этгээдийн.

14.4.Хорооны гишүүдийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хянан үзэж, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн ийм саналууд бол байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 13 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15 дугаар зүйл болгох:

“15.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх

15.1.Энэ хуулийн 14.3-т заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

15.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр болон эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга мэдээлэл авах;

15.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас тайлбар, нэмэлт тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;

15.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;

15.1.4.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;

15.1.5.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах.

15.2.Дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт 10 өдөр өнгөрсний дараа, эсхүл биечлэн гаргуулснаар дээрх этгээдэд мэдэгдсэнд тооцно:

15.2.1.гомдол, мэдээлэл гаргасан этгээд;

15.2.2.зөрчилд холбогдсон төрийн албан хаагч;

15.2.3.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага.

15.3.Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

15.4.Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоног нэг удаа сунгаж болно.

Иргэний гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

15.6.Дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд, түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороо, Хороонд гомдол гаргана.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.7.1.дүгнэлтийг хэвээр үлдээх;

15.7.2.дүгнэлтийг хүчингүй болгох.” гэсэн ийм өөрчлөлтүүд заалтууд байна. Санал хураалт. Ажлын хэсгийн саналыг.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Баярсайхан гишүүнд микрофон өгье.

Б.Баярсайхан: Тодруулъя. Түрүүний нөгөө асуусан асуулт дээрээ. Өмнөх ажил дээрээ ямар нэгэн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан хүнийг дараагийн албан тушаалд томилохдоо, томилох юм уу, томилохгүй юм уу гэдэг л түрүүн би нөгөө ноцтой хөнгөн зөрчил гэж байхдаа энэ дээр бол яг 15-ын 1-ийн 7 дээр ёс зүйн шийтгэлтэй этгээдийг төрийн албанд шинээр томилохыг хориглоно. Өмнөх ажил дээр ёс зүйн асуудал гаргаж байсан бол нөгөө дэвшилгүйг хориглоно тийм ээ. Ажил үүргийг нь үнэлэхдээ ёс зүйн хандлагыг нь харна. Ёс зүйн зөрчил гаргасан бол тэдээс тэдэн жилийн хугацаанд төрийн албанд томилохгүй байх нөхцөлтэйгөөр төрийн албанаас хасах гэдэг юм уу 1 ийм л асуудлууд илүү жоохон чамбайрч орж ирэх ёстой юм болов уу гээд хараад байгаа. Энэ 15 дугаар зүйл дээр хамаатай юу. Баттөмөр дарга аа, энэ нөгөө ажлын хэсэг маань өөрчлөгдөөд дахиад хууль маань өөрчлөгдсөн байна тийм ээ.

Б.Баттөмөр: Тийм, юу ажлын хэсэг байгаа 1 дүгээр микрофон Бат-Эрдэнэ хариулъя.

ТАЗ-ийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ байна. Гишүүний асуултад хариулъя. Гишүүний бас энэ асуултын агуулгад хамаарах энэ заалтыг хуулийн төслийн 9-ийн 1-ийн 4-д бид бүхэн бас оруулж өгсөн байж байгаа. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах гэдэг ийм заалтаар оруулж өгсөн, шаардлагатай гэж үзэх юм бол бас энэ заалт дээрээ илүү бас томъёолол дээр нь ажиллах боломж бас байгаа гэж харж байна.

Б.Баттөмөр: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Ажлын хэсгийн

саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 14 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн томъёоллоор санал хураалга.

18.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16 дугаар зүйл болгох:

“16 дугаар зүйл.Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх

16.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Хороо, Дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:

16.1.1.гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;

16.1.2.өөрт болон ганцаарчилсан хэлбэрээр сануулах;

16.1.3.байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;

16.1.4.төрийн албанаас халах.

16.2.Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

16.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан Төрийн албаны тухай хуулийн 37, 39

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасныг зөрчсөн бол тухайн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

16.4.Төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.5.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гарснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

16.6.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.” гэсэн ийм 6 санал байна. Энэ ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 15 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн саналын томъёоллоор санал хураалгая.

Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох:

“17 дугаар зүйл.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураар хүлээх

17.1.Хороо, Дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол

түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

17.2.Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:

17.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;

17.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.” гэсэн ийм заалтууд бол байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 16 дугаар зүйлийг санал хурааж дууслаа.

Төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс энэ 17 дугаар зүйл дээр бол хэсгээс санал гараагүйг. 17 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн саналыг хураалгая.

Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар найруулж, 19 дүгээр зүйл болгох:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.

19.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.

19.3. Хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хүргүүлнэ.

19.4. Хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.” ингээд ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна. 18 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс энэ төсөл дээр болбол санал гаргаагүй хэвээрээ батлагдаж байна.

Найруулгын шинж чанартай 1 санал байна.

21. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл шинээр бүлэг, хэсэг, зүйл заалт нэмэгдэж хасагдсантай холбогдуулан төслийн бүтэц, дугаарлалт, найруулгыг холбогдолтой өөрчлөлт оруулах.

Ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсэг гаргасан томъёоллыг хэлэлцье.

1 дүгээрт нь, төрийн албаны тухай.

Энд жоохон алдаа гарсан байна. 21 дүгээр зүйлээр санал хураалт явуулах юм байна. Санал хураалт.

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал хураалт.

57.1%-аар санал дэмжигдэж байна.

Төслийн 3 дугаар зүйлийн “37.1.12” гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалт, уучлаарай энэ миний төхөөрөмж ажилласангүй, уучлаарай, дахиж санал хураалт явуулъя. Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1%-аар дэмжигдэж байна.

Санал хураалт явуулъя, саяын түрүүчийн санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

57.1%-аар санал дэмжигдэж байна.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөх тухай хуулийн төсөл.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

57.1%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөгдөх хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор.

4. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай болон хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл.

1. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх:

“2/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлгээс гадна зарлагын мэдүүлгийг мэдүүлж байх талаар санал боловсруулж, холбогдох хуульд тусгах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн ийм заалт байгаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

57.1%-аар дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

УИХ-ын чуулганы хуралдаанд санал, дүгнэлтийг унших УИХ-ын гишүүнээр би уншихъя даа тэгээд. Баттөмөрийг томиллоо.

Ингээд Ёс зүй, сахилга харууллагын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан тул өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

Ажлын хэсгийн дарга, гишүүдэд баярлалаа. Та бүгдэд. Маргааш нэгдсэн чуулганаар орох байх. Тэгээд бүгдээрээ энэ дээр оролцоно оо.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ